

Номч мэргэн гэгээн Л. Лувсандамбийдомэйн намтар, домог, өв

Ганболдын БАТМӨНХ*

Монгол Улс, Улаанбаатар хот, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Аман зохиол судлалын салбар

Дамдинбаатарын ЛХАГВАГЭРЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Их Сургууль, Хууль зүйн сургууль

Received: 31 May 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Өгүүлэлд Засагт хан аймгийн Сартуул сэцэн засгийн хошууны Хорло цорж ламын VI дүр Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн намтарт холбогдох зарим мэдээ баримт, судлаачдын бүтээлд буй он цагийн зөрүү, уран бүтээлийг хэвлэн нийтэлсэн байдал зэргийг тодруулж өөрийн санал дүгнэлтийг дэвшүүлжээ. Мөн зохиогч өндөр настан Дагвын Нямаас тэмдэглэж авсан Номч мэргэн гэгээний аман домгийг урьд нь хэвлэгдсэн хоёр хувилбартай харьцуулж, хувилгааны эдэлж хэрэглэж байсан эрх, аяга, шоо нь түүний шавь А.Натсүрэнгийн удмынханд өдгөө хадгалагдаж буйг өгүүлжээ.

Түлхүүр үгс: хувилгаан, домог, намтар, Лувсанравдандорж

**Biography, Legend and Heritage
of Nomch mergen geegen L.Luvsandambiidomei**

BATMUNKH Ganbold

Department of the Folklore Studies, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia

LHAGVAGEREL Damdinbaatar

School of Law, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Abstract: The article clarifies some facts related to the biography of Nomch Mergen Geegen L. Luvsandambiidome, the 6th reincarnation of Khorlo Chorji Lama from the Sartuul Setsen Zasag banner of Zasagt Khan aimag. It also addresses discrepancies in dates found in researchers' works and the publication status of his artistic works, offering the author's own proposals and conclusions. Furthermore, the author compares an oral legend about Nomch Mergen Geegen, recorded from the elderly Dagva's Nyama, with two previously published versions. The article also notes that the reincarnation's personal possessions, specifically his mala, bowl, and dice, are currently preserved by the descendants of his disciple A. Natsuren.

Key words: Incarnation, Legend, Biography, Luvsanravdandorj

* © Author(s), 2025, Email: batmunkhg@mas.ac.mn.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license

1. Удиртгал

Олноо Номч мэргэн гэгээн хэмээн алдаршсан Засагт хан аймгийн Сартуул сэцэн засгийн хошууны Хорло цорж ламын VI дүр Л.Лувсандамбийдомэй (Лувсанравдандорж, Равдандорж, Чадраабал, Цэдэнбал, Хорло цорж зэрэг олон алдраар тэмдэглэсэн байдаг) бол Ханхөхий уулын хошууны засаг ноён Сэдбазарын Лувсандондов буюу “Бурхан жанжин гүн ноён”-ы хүү бөгөөд бага насандаа Хорло цорж ламын хойд дүрээр тодорч Сартуул сэцэн засгийн хошууны Тэгшийн хүрээнд залагдаж, бурхны шашны ном эрдэмд суралцаж байгаад мэдлэг боловсрол, номын хүчийг арвитгахаар Төвөд, Энэтхэг, Өвөрмонголд олон жил ном үзэж, Алшаа нутагт “Алтан тэвшийн хийд”-ийг байгуулан суужээ. Тэр бээр “...1920-оод оны үед бурхны шашны эрдмийн дээд цол болох лхаарамбын дамжаа барьж, дараа нь Төвөдөөс Энэтхэгт хүрч зуун өдрийн хатуу бясалгалд сууж, Энэтхэг, Төвөд, Шриланк зэрэг олон газрын лам, хувилгаадын дотроос шалгаран үлдэж, Доржданын өмнө “Сожингийн их до” тавьж, Бурхан багшийн ураг төрлийн бөгөөд түүний дотнын шавь Гунгаабуу архдын хувилгаан дүрээр тодорсон ажээ [Сайннямбуу, Бат, 2005: 3].

Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн намтарт холбогдох зарим мэдээ баримт, уран бүтээлийг нь хэвлэн нийтэлсэн байдал, шашин номын үйл ажиллагаа зэрэг нь тэр бүр тодорхойгүй байна. Номч мэргэн гэгээний талаар тусгайлан бичсэн Ц.Сайннямбуу, Д.Бат нарын “Ханхөхийн хошууны ноён Лу жанжин гүний хөвүүн Номч мэргэн гэгээнтэн” (Тайвань, 2005) ном болон түүний аав “Бурхан жанжин гүн” буюу С.Лувсандондовын тухай судалгааны бүтээлүүдэд Номч гэгээний тухай дурдсан зүйлс нэлээд тохиолдох боловч хоорондоо үлэмж зөрөөтэй байна. Тэдгээр баримтаас үзвэл, Номч гэгээний мэндэлсэн он, нэр, Лу жанжин гүний хэддүгээр хүү болох, Хорло цорж ламын хойд дүрээр тодорч одоогийн Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Тэгшийн хүрээнд залагдсан он, нас барсан он зэрэг түүний намтарт холбогдох гол баримтууд нь судлаачдын бүтээлүүдэд зөрөөтэй тэмдэглэгджээ.

2. Судалгааны арга зүй

Бид энэхүү өгүүлэлд Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн төрсөн он, нэр, хувилгаанаар тодорч хийдэд суусан он, Төвөд, Өвөрмонголд явсан он, түүний зарим уран бүтээлийг хэвлэн нийтэлсэн байдал, жанч халсан он зэргийг тодруулан, аман домгийн хувилбаруудыг харьцуулж, түүний бичээч асан А.Натсүрэнгийн удмынханд хадгалагдаж буй өвийн тухайд мэдээлэхийг зорилоо.

3. Номч мэргэн гэгээний намтрыг тодруулах нь

Түүний мэндэлсэн он, нэр, Лу жанжин гүний хэддүгээр хүү болох тухайд судлаачдын саналыг он цагийн дарааллаар авч үзвэл,

1. Судлаач М.Гүрсэд, Б.Амаржаргал, Ц.Баярсүрэн нарын эмхэтгэн, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн “Дурсгалт бичгийн чуулган” цувралын XXIV дугаарт хэвлэсэн “Шүлэгч Лувсандондовын бүтээл” номд “Лувсандондовынх дөрвөн агь, зургаан авхай бүгд арван хүүхэдтэй. Хатан Номиндарь буюу, олны нэрлэдгээр “Ээж дархай”¹ нь ажилсаг зарчимтай хүн байжээ. ...Ууган хүү Цэдэнбал нь багаасаа хувилгаан лам гэж өргөмжлөгдсөн бөгөөд эцгийгээ амьд сэрүүнд Баруун зууд (Лхас) яваад буцаж ирээгүй” [1989: 8] гэх буюу нэр нь Цэдэнбал, С.Лувсандондов гүний ууган хүү гэсэн байна.
2. Судлаач М.Гүрсэд “Лу гүний ууган хөвгүүн Цэдэнбалыг багаасаа хувилгаан хэмээн өргөмжлөгдөж, Сартуулын хошуунд залагдсан гэж ярилцдаг. Ингээж ч бичсээр иржээ. Үүнээс өөрийг дуртган өгүүлсэн нь бараг үгүй” [2001: 66] гээд Номч мэргэн гэгээнийг хувилгаанаар тодорсон тухайд “Улсын төв архивд буй “Сартуулын ноёд хийгээд

¹ Хатны нэр Номиндарь (Номиндара эсвэл Номундара) гэдэг тул “Ээж дархай” бус “Ээж дара ахай” бололтой.

хувилгаадын угийн бичиг”-т “...номч хутагт Дандарванжил Бадаргуултын долоон онд (1881 он) жанч халав. Энэ хувилгааны хойд дүрийг гүн Лувсандондовынхоос Бадаргуултын 15 (аргын 1889) онд тодруулан залж Богд гэгээнээс хамбын ямба бүрэн шагнаж, шар торгоны бичиг нэг хувийг олгов. Хувилгааныг Лувсанравдандорж хэмээнэ. Далай ламаас Лувсанравдандорж хувилгаанд “Номд дуртай” цол, шар торгоны бичиг нэг хувийг олгов. Хувилгаан олноо өргөгдсөний VIII онд төрийн хэрэгт 400 лан мөнгө тусалсан учир “мэргэн хурц билигт” цолоор шагнагдсан болно...” гэж тэмдэглэсэн” [Гүрсэд, 2001: 67] байна гэжээ. Мөн 1994 онд Улаанбаатар хотын Сансар хороололд амьдарч байсан Лу жанжин гүний зээ хүү Д.Ондог хэмээх хүнээс уг удмынх нь талаар дараах байдлаар тэмдэглэж авчээ. “Буурал аавынх (элжигэн халхчууд өвөг эцгээ ингэж нэрлэдэг) дөрвөн агьтай нэрлэвэл ууган хөвгүүн Цэдэнбал (хувилгаан), удаах хөвгүүд Гончигдамба (Го сайд хэмээн алдаршсан), мэргэн Чагдаржав, тайж Цанцгар нар. Таван ахайтныг нэрлэвэл Гонгир, Дигаа, Гүнсэн, Норжмаа, Ханд нар. ...Миний ээж Норжмаа бол Лу гүний дөрөв дэх авхай. Ноёны авхайтай гэрлэсэн учир эцгийг минь Донгоо тавнан хэмээн нэрлэдэг байжээ” [Гүрсэд, 2001: 74]. Энд өгүүлснээс үзвэл дээрх номд бичсэнчлэн нэр Цэдэнбал, ууган хүү гэжээ. Харин зөрж буй зүйл нь өмнөх номд Лу жанжин гүнийх 4 агь, 6 авхай бүгд 10 хүүхэдтэй гэсэн бол энд 4 агь, таван авхай нийт 9 хүүхэд нэрлэжээ. Мөн Лувсанравдандорж гэдэг нь Номч гэгээний өөр нэгэн алдар болохыг тэмдэглэхийн дээр 1889 онд хувилгааны хойд дүрээр тодруулан залсан гэжээ.

3. Судлаач Б.Амаржаргал, Б.Палам нарын номд “Лувсандондов гүний хатан Номиндарь буюу хошууныхны нэрлэдгээр “ээж дархай” туйлын ажилсаг зарчимч нэгэн байжээ. Тэднийх 4 агь 6 авхай, бүгд 10 хүүхэдтэй байв. ...Ууган хүү Л.Цэдэнбал нь багаасаа номын мөр хөөж лам болоод хувилгаан гэж өргөмжлөгдөн, эцгийгээ амьд сэрүүн цагт Баруун Зуу буюу Лхас яваад эргэж ирээгүй гэдэг” [Амаржаргал, Палам, 2004: 17-18] хэмээн “Шүлэгч Лувсандондовын бүтээл” номд өгүүлсэнтэй ижил буюу нэр нь Л.Цэдэнбал, С.Лувсандондов гүний ууган хүү, тэднийх 10 хүүхэдтэй байсан гэжээ. Судлаач Б.Амаржаргал дээрх номуудад зохиогчоор оролцсон учир өмнөх номын үндсэн мэдээллүүдийг тэр хэвээр нь авч, найруулгыг бага зэрэг өөрчилсөн бололтой.
4. Номч мэргэн гэгээний намтар, шашин номын үйл ажиллагааны талаар тусгайлан судалсан судлаач Ц.Сайннямбуу, Д.Бат нарын бүтээлд “XIX зууны сүүлч XX зууны эхээр олноо Ханхөхий хошууны “Бурхан жанжин ноён” хэмээн алдаршсан төр, нийгмийн томоохон зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, яруу найрагч Лу жанжин гүн буюу Сэдбазарын Лувсандондовын ууган хүү болж 1879 онд төрсөн Л.Цэдэнбал (энэхүү номд Равдандорж, Хорло цорж, Лувсандамбийдомэй гэдэг нэрээр бичигдсэн) нь бага балчир насандаа Цэцэн сартуул хошууны гэгээнтэн Хорло цорж ламын хойд дүрийн хувилгаанаар тодрон, 1884 онд Тэгшийн хүрээнд (одоогийн Завхан аймгийн Цэцэн-Уул суманд)” [Сайннямбуу, Бат, 2005: 3] залагдсан гэсэн байна. Энд мөн л нэр Цэдэнбал, С.Лувсандондовын ууган хүү гээд 1879 онд төрсөн, 1884 онд Тэгшийнд хүрээнд залагдсан гэжээ.
5. Судлаач О.Нарангэрэл “Сартуулын Хорло цоржийн хувилгаан хэмээх номч хутагтын зургаадугаар дүр Мэргэн хурц билигт хутагт Л.Равдандорж /Лувсандамбийдомэй/ (1879-1954) болой. Тэр бээр Засагт хан аймгийн хан хөхий уулын хошуу, Элжигэн сартуулын ноён, халх даяар яруу найрагч, соён гэгээрүүлэгч, мэргэн хуульч “Лу жанжин гүн” хэмээн алдаршсан С.Лувсандондов (1854-1908)-ын ууган хүү болон мэндэлжээ. Түүнд эцэг эхээс хайрласан нэр нь Л.Цэдэнбал, Монголын бурхны шашны түүхэнд тэмдэглэсэн сахилын нэр нь Л.Равдандорж, Төвөдөд гэгээрсэн сахилын нэр нь Л.Лувсандамбийдомэй болой” [Нарангэрэл, 2014: 256] гэж өмнөх номын адилаар нэр Цэдэнбал, С.Лувсандондовын ууган хүү, 1879 онд төрсөн хэмээжээ.
6. Судлаач Г.Пүрэвдорж “Тэгшийн хүрээг Хорол цорж буюу хутагт хэмээн дуудуулагч Дандарванчиг гэдэг эрдэмт мэргэн лам олон лам хуврагийг тэргүүлэн суудаг байжээ. Хүрээний сүүлчийн тэргүүн буюу Дандарванчиг ламын дараагийн дүр нь Хан хөхийн хошууны засаг ноён Лувсандондовын хүү Равдандорж ажээ. Номч хутагт хэмээх Равдандорж нь Лувсандондов ноёны хүү болон мэндэлж Сарт хошуунд залагдсан боловч

хориод насандаа Энэтхэг, Төвөдөөр дамжин эргэл мөргөл хийн ном үзэх, сурахаар номын мөр хөөж бадарчийн ёсоор тэнүүчлэн явсаар өнгөрсөн юм гэж ахмадууд дурссан нь бий” [Пүрэвдорж, 2017: 236] гэснээс харвал, С.Лувсандондовын хүү, нэр нь Равдандорж гэсэн байна.

7. Харин судлаач Д.Түмэнжаргал өмнө өгүүлсэн Ц.Сайннямбуу, Д.Бат нарын “Ханхөхийн хошууны ноён Лу жанжин гүний хөвүүн Номч мэргэн гэгээнтэн” хэмээх номыг дурдаад, эл номд “*Номч мэргэн гэгээний жинхэнэ нэр, төрсөн он, Лу гүний хэддүгээр хүү болох, Сартуулд залагдсан он, нас зэрэг нь архивын материалуудаас зөрж байна. ...тус номд түүнийг “1879 онд төрсөн, Лу гүний ууган хүү, 1884 онд хувилгаанаар Тэгшийн хүрээнд залагдсан, нэр нь Цэдэнбал хэмээн бичигджээ. Цэдэнбал биш Чадраабал юм байна”* [Түмэнжаргал, 2017: 128] гэжээ. Тэр бээр Лу гүний 1884 онд Богд Жавзандамбаас аврал эрж, ам бүлийнхээ нас жилийг тодорхойлсон захидалд “*...Энэ жил Лувсандондов 31 нас, барс жил, Ижий Роломцог 60 нас, тахиа жил, эргий Дарьжав 27 нас, морин жил, ахмад хөвгүүн Дорлигжав 7 нас, барс жил, хоёрдугаар хөвгүүн Пунцагнамжил 6 нас, туулай жил, гуравдугаар хөвгүүн Чадраабал 2 нас, хонин жил, охин Түмэнжаргал 10 нас, гахай жил, охин Эрхэмжаргал 4 нас, нохой жил эдгээр 8 ам...*” [Түмэнжаргал, 2010а: 389] гэж бичсэн мөн 1900 онд Жалханз гэгээн Дамдинбазарт илгээсэн захидалд “*...Лу 47 нас барс жилтэй. Гэргийтэн 43 нас морь жилтэй, ахмад хөвгүүн Го 22 нас туулай жилтэй, 2-р хөвгүүн Чадраабал 18 нас хонин жилтэй...*” [Түмэнжаргал, 2010а: 409] хэмээсэн захидлуудыг үндэслэн Номч мэргэн гэгээн бол Лу жанжин гүний 3-р хүү, нэр нь Чадраабал хэмээн үзжээ. Тэр бээр мөн дээрх захидлуудыг үндэслэн “*Лу гүний анхны хүүхэд нь Дорлигжав байсан, тэр нь 1900 он гэхэд нас барсан байсан учир 1884 онд Чадраабал Лу гүний 3 дахь хүүхэд байсан бол 1900 онд 2 дахь хүү гэж бичигджээ. Хоёр захидалд бичсэн нас одоогийнхоор биш хуучнаар 1 нас илүү явдаг тул (1884-1=1883 он, 1900-17=1883) төрсөн нас жил нь 1883 он, хонин жил гэдэг нь тохирч байна*” [Түмэнжаргал, 2017: 128] гэжээ. Эдгээрийг товчилбол, нэр нь Цэдэнбал бус Чадраабал, С.Лувсандондовын гуравдугаар хүү, 1883 оны хонин жилд төрсөн гэж үзжээ.
8. Судлаач Л.Гомбожав “*С.Лувсандондовынх өнөр бүл байжихуй. Аваал хатан нь Дэлгэрэх, Дарьжав нар. Тэднийд зургаан агь, зургаан авхай заяаж, ноён эцэг, хатан эхээ баясгасан боловч зарим нь хүүхэд насандаа эндэж, аав, ээжийнхээ элгийг эмтэлж, голыг харлуулсныг намтрын товчоон гэрчилдэг. Зургаан агь нь: Дорлигжав (долоон насандаа үрэгдсэн), Гончигдамба, Чадраабал, Чагдаржав, Данзанжигмэд (12 насандаа эндэжээ), Данзан-Очир болой. Зургаан авхай нь: Гонгор (Түмэнжаргал), Гонгир (16 настайдаа нас баржээ), Дигаа, Гүнсэнжав, Норжмаа, Ханд нар*” [Гомбожав, 2017: 9] гээд судлаач Д.Түмэнжаргалын дээрх саналыг дэмжсэн байна. Мөн тэр бээр “*Түүхч, судлаач Д.Түмэнжаргал багшитаны архивын баримт мэдээллийг үндэслэн нотолсноор Сартуулын хошууны Данзанванчигийн хойд дүр, жинхэнэ нэр нь Чадраабал, номын нэр нь Равдандорж, Хорол цорж, Түвд, Өвөрмонголд авсан номын нэр нь Лувсандамбийдоомий гэдэг юм байна. Өөрөөр хэлбэл Лу гүний хөвгүүн Чадраабал олон алдар нэртэй байжихуй. Лувсанравдандорж гэж Чадраабалын алдар нэрийн нэг хувилбар юм*” [Гомбожав, 2017: 28], “*Номч мэргэн гэгээнтэн хэмээн алдаршсан Л.Чадраабал (Равдандорж, Хорло цорж, Лувсандамбийдоомэй зэрэг сахилын нэртэй) эцэг Лу жанжин гүний өргөөнд тарвалзан өсөж ахуй бага балчир насандаа Цэцэн Сартуул хошууны гэгээнтэн Хорло цорж ламтны хойд дүрийн хувилгаанаар тодрон, 1888 онд Тэгшийн хүрээнд залагдаж, бурхан номын үйлсэд бие, хэл, сэтгэлээ зориулах болсон*” [Гомбожав, 2017: 31] гэсэн байна. Ийнхүү нэр нь Чадраабал, С.Лувсандондовын гуравдугаар хүү, 1888 онд Тэгшийн хүрээнд залагдсан гэсэн байна. Мөн өмнөх судлаачдын бүтээлд Лувсандондов гүнийх 10 хүүхэдтэй гэж тэмдэглэсэн бол энд 12 хүүхдийн нэрийг тодорхой хэлж, судлаач Д.Түмэнжаргалын судалгаанд өгүүлсэнчлэн ууган хүү Л.Дорлигжав бага насандаа эндсэн болохыг хэлжээ.

Дээрх судлаачдын бүтээлээс үзэхэд, Номч мэргэн гэгээний нэр, төрсөн он зэргийн тухайд судлаач Д.Түмэнжаргал, Л.Гомбожав нарын санал нэлээд үндэстэй, тодорхой баримтад тулгуурласан болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Лу жанжин гүний ууган хүү

Л.Дорлигжав бага насандаа эндсэнийг үл мэдсэний улмаас, мөн архивын баримтуудад Лувсандондовын хоёрдугаар хүү Л.Гончигдамба хэмээн бичсэнээс үүдэж Л.Чадраабалыг ууган хүү юм байна хэмээн үзэж дээрх мэт ном бүтээлд ташаарах болсон бололтой.

Судлаач Д.Түмэнжаргалын эрхлэн хэвлүүлсэн ноёдын захидал харилцааны бичгүүдээс үзвэл Л.Чадраабалын ах Засаг ноён Л.Гончигдамбын захидал бичигт нас жилийг дээрхтэй адил тодорхойлон бичжээ. Тухайлбал, 1911 онд Л.Гончигдамба Богд Жавзандамбад өргөсөн захидалд *“Эдүгээ энэ жил Гончигдамба 33 нас туулай жилтэй, дүү хувилгаан гэлэн Равдандорж 29 нас хонин жилтэй, энэ Баруунзуугийн Галдан хийдэд сургуулиар сууж буй...”* [Түмэнжаргал, 2010б: 13] гэсэн бол 1918 онд Дархадын дарга нарт бичсэн захидалд *“Жүн ван Го би энэ жил 40 нас тэмдэглэсэн хөвгүүн тэргүүн зэрэг тайж Чимид 13 нас, жич дүү хувилгаан лам Чадраабал 36 нас...”* [Түмэнжаргал, 2010б: 40] хэмээжээ. Дээр өгүүлсэнчлэн хий насыг хасаж тооцвол 1911-28=1883, 1918-35=1883 болж таарч байна. Ийнхүү ах Л.Гончигдамбын захидлуудад нас жилийг дээрхтэй адил тодорхойлон бичсэнээс гадна Номч мэргэн гэгээн ах Л.Гончигдамбад бичсэн захидалд:

“Дүү хувилгаан Чадраабал хичээнгүйлэн:

Өршөөлт гүн ноён ах танаа шинэ жилийн түмэн амгаланг айлтгаж барив. ...Энд гэгээнтэн эгэл бид бүгд хэвийн мэнд сайныг сонсгохоос гадна дүү хувилгаан би ах ноён танаа бараалхахыг хүссэн боловч энэ тухай чадахгүй тул ноён ах минь эрхбиш энэ зун морилон ирж, цэнгэн баярлахыг гуйж, өршөөлт гүн ноён ах танаа шинэ жилийн түмэн амгаланг айлтгаж барив. Жич гуйн айлтгах нь: 130 хушин банз, мужаан Цэрэвийг модны бүрэн багажтай энэ 5 сард ирүүлмү. Зоог, хэрэглэл зүйлийн хөлсийг ямар бөгөөс өгсүгэй хэмээн гуйсныг эрхбиш бүтээмү” [Түмэнжаргал, 2010б: 144] гэснээс үзвэл Л.Гончигдамба Номч мэргэн гэгээний ах нь байсан нь тодорхой байна.

Судлаачдын санал болон захидал бичиг зэргээс үзэхэд Номч мэргэн гэгээн С.Лувсандондовын гуравдугаар хүү, нэр нь Л.Чадраабал бөгөөд Лувсанравдандорж (Равдандорж) гэдэг нь түүний Монголд авсан сахилын нэр, Лувсандамбийдомэй (Лувсандамбийдонмэ) хэмээх нь Төвөд, Энэтхэгт авсан сахилын нэр нь ажээ. Тэр бээр 1883 оны хонь жил төрж, 1886 (1887) оны орчим Тэгшийн хүрээнд залагдсан байна. Харин Төвд, Өвөрмонголд явсан оны хувьд судлаачид янз бүрээр тэмдэглэсэн байх бөгөөд жанч халсан оныг 1954, 1966 он хэмээсэн, Хорло цорж ламын өмнөх дүрийн нэрийг *Дандарбанчин, Дандарванчиг, Данзанванчиг* зэргээр ялгаатай бичсэн байх тул үүнийг цаашид нягтлан тодруулах шаардлагатай байна.

4. Номч мэргэн гэгээний уран бүтээлийг хэвлэн нийтэлсэн нь

Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн “Алтан тэвшийн хийд”-д очоод бүтээж туурвисан ном бүтээлийг судлаач Ц.Сайннямбуу, Д.Бат нар номдоо нэлээд тодорхой, олон талын баримт ашиглан дэлгэрэнгүй бичсэн нь тун сайн судалгаа болжээ. Харин Монголд байхдаа туурвисан дуу, шүлгийн тухайд бол судлаачид “Гансрах сэтгэл” шүлэг, “Хөхий уулын шил”, “Хөхий хангай унага” дууг нэрлэдэг. Анхлан судлаач М.Гүрсэд *“Миний бие оюутан ахуйдаа 1964 онд Увс аймгийн Өндөрхангай сумын дууч-найрч Чулуужавын Мишигийн хадгалж асан бичмэл дэвтрээс Лу гүний дуу шүлгүүдийг хуулбарлан авч билээ. Уг дэвтрт бичсэн бүхнийг бүрэн хуулж авснаа эдүгээ хүртэл хадгалж байна. Тэр дэвтрийн төгсгөлд “Номч хутагт Лувсанравдандоржийн бүтээл” гэсэн нэрийн дор “Гансрах сэтгэл” шүлэг, “Хөхий уулын шил”, “Хөхий хангай унага” дууг тус тус бадагчлан тэмдэглэсэн байв.*

Лувсанравдандорж гэж хэн бэ? Тэгэхэд Мишиг гуай ч надад товтой, лавтай юм хэлсэнгүй. Лувсандондов, Лувсанравдандорж гэж хоёр өөр хүн байх нь хооронд нь хутгаад яах вэ гэж бодсоноос Лувсанравдандоржийн дуу шүлгийн тухай дурсалгүй эдүгээг хүргэсэн юм.

Гэтэл зарим судлаач “Хөхий хангай (уулын)² шил”, “Хөхий хангай унага” дууг Лу гүний бүтээлийн жагсаалтад оруулсан нь гайхааш төрүүлэв [Гүрсэд, 2001: 66-67] гээд эдгээр дуу шүлгийг Номч хутагт Лувсанравдандоржийн бүтээл хэмээн хэвлэжээ. Дээр өгүүлсэнчлэн Лувсанравдандорж гэдэг нь Л.Чадраабалын нэр мөн тул түүний зохиосон эдгээр дуу, шүлгийг хэрхэн хэвлэн нийтэлж ирснийг дор үзүүлбэ.

1. Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская нарын эмхэтгэсэн “Монгол ардын уртын дуу” (1984) түүврийн 206-р талд “Хөхий уулын шил” дууг “Хөх уул” нэрээр 7 бадгаар хэвлэсэн байна. Ингэхдээ “1, 3-р бадгийг Архангайгаас олдсон 300 дууны бичмэл түүврээс (МДСТТ 120-121-р тал), бусад бадгийг ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн гар бичмэлийн хөмрөгийн F-129 гэсэн дугаарт буй “Олон дууны бичмэл энэ амуй” гэсэн бичмэл түүврээс” [Монгол ардын уртын дуу, 1984: 206] авчээ.
2. М.Гүрсэд, Б.Амаржаргал, Ц.Баярсүрэн нарын эмхэтгэсэн “Шүлэгч Лувсандондовын бүтээл” (1989) номын 99-р талд “Хөхий уулын шил” дууг С.Лувсандондовын бүтээлд оруулж 4 бадгаар хэвлэжээ. Тус дууны тайлбарт “Увс аймгийн Зүүнхангай сумын Б.Бамбадоржийн уртын дууны гар бичмэлээс Б.Амаржаргалын тэмдэглэснийг үндсэн эх болгон I хувилбар гэж авав. Мөн Зүүнхангай сумын Л.Дагдоржоос шинжилгээний ангийнхан бичиж авсан эхийг II хувилбар болгон харьцуулж зөрөөтэй үгийг хаалтад хийв. I хувилбар нь хоёр бадгаар илүү байсныг бүрнээр нь оруулав” [Шүлэгч Лувсандондовын бүтээл, 1989: 99] гэжээ.
3. Дээр дурдсан судлаач М.Гүрсэдийн “Цагийг эзэлсэн дууч Сэдбазарын Лувсандондов гүн” (2001) номын 69-71-р талд “Гансрах сэтгэл”, “Хөхий уулын шил”, “Хөхий хангайн унага” бүтээлүүдийг анх удаа Номч мэргэн Лувсанравдандоржийн бүтээл хэмээн хэвлэсэн байна. Энд хэвлэсэн эх бол 1964 онд Увс аймгийн Өндөрхангай сумын дууч-найрч Чулуужавын Мишигийн хадгалж асан бичмэл дэвтрээс судлаачийн хуулбарлан авсан эх бөгөөд бидний өмнө өгүүлсэн “Хөхий уулын шил” дууг 4 бадагтайгаар нийтэлжээ.
4. Судлаач Ц.Сайннямбуу, Б.Бат нарын “Ханхөхийн хошууны ноён Лу жанжсин гүний хөвүүн Номч мэргэн гэгээнтэн” (2005) номын 25-р талд “Номч хутагт Лувсанравдандорж (Цэдэнбал)-ийн зохиосон гэх “Ханхөхий уулын шил” дуу, “Гансрах сэтгэл” шүлэг байдаг бөгөөд энэ удаа түүний “Хөхий хангайн унага” гэсэн дууны шүлгийг толилуулсу” [Сайннямбуу, Бат, 2005: 25] гээд энэ шүлгийг нь хэвлэжээ.
5. Судлаач Д.Өрнөхдэлгэр “Гүн найрагч Сэдбазарын Лувсандондов: Намтар, уран бүтээл” (2020) номын 14-р талд “Гансрах сэтгэл”, “Хөхий уулын шил”, “Хөхий хангайн унага” бүтээлүүдийг Номч мэргэн Л.Лувсанравдандоржийн бүтээл хэмээн хэвлэсэн байна. Эдгээр дуу, шүлгийг М.Гүрсэдийн номд буй эхийг баримталж хэвлүүлсэн бололтой байна.

Энэхүү дуу, шүлгүүдээс олон зохиогчийн нэрээр хэдэн хэдэн хувилбараар хэвлэгдсэн нь “Хөхий уулын шил” дуу бөгөөд хэвлэсэн байдлыг дор харгуулан үзье.

Хүснэгт 1. “Хөхий уулын шил” дууг хэвлэсэн хувилбарууд

Д/д	1.	2.	3.
-----	----	----	----

² “Хөхий уулын шил” дууг “Хөхий хангай шил” хэмээн андуурсан бололтой. Судлаач эл номд дууг эхээр нь хэвлэхдээ “Хөхий уулын шил” гэж зөв бичсэн байв.

Хэвлэсэн ном	Монгол ардын уртын дуу. 1984. Эмхэтгэсэн Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская. Ред. Д.Цэрэнсодном. Уб., х. 206	Шүлэгч Лувсандондовын бүтээл. 1989. Дурсгалт бичгийн чуулган, Tom. XXIV, fasc. 1. Эмхэтгэсэн М.Гүрсэд, Б.Амаржаргал, Ц.Баярсүрэн. Редактор Ж.Цолоо. Уб., х. 99	1. Гүрсэд М. 2001. Цагийг эзэлсэн дууч Сэдбазарын Лувсандондов гун. Уб., х. 70 2. Өрнөхдэлгэр Д. 2020. Гүн найрагч Сэдбазарын Лувсандондов: Намтар, уран бүтээл. Редактор А. Батсуурь, Д. Ганболд. Уб., х. 14
Дууны нэр	Хөх уул	Хөхий уулын шил	Хөхий уулын шил
Шүлгийн эх	- Хөх уулын шилд Хүйтэн будан татна Хөөрхий бяцхан чамайгаа Мартахын сэтгэл үгүй - Хадат өндрийн оройд Хамгийн бараа илхэн Хайрласан хайрыг нь бодоход Харихын дур үгүй л - Өндөр дээр гарахад Өөрийн нутаг илхэн Өөрийн дураар явъя гэхүл Жанжны зарлиг хатуу - Хадтай газар бартаатай биш үү Галигуулсхийж яваарай Харанхуй шөнө будантай биш үү Мэдэсхийж яваарай - Харийн хүмүүн хартай биш үү Сэрэмжилж л яваарай - Яасан хол газар вэ Агтын хүч сульдуузай Ямар ч чиг амраг сэтгэл вэ Яагаад алмайрч мартах вэ - Хоёр нутгийн холыг Хонгор минь мэдэмзээ Хойт юугаа бодохуйд Мордохын зөв л мэдүүлье	Хөхий уулын шилд Хүйтний будан татна Хөөрхий мэлмэгэр чамайгаа Мартахын сэтгэл үгүй Хадат өндрийн оройд (II. оройгоор) Харанхуй будан татна Хайрласан хайры (II. сэтгэлий) чинь бодоход Харихын сэтгэл үгүй ээ (II. Харин ч дотор минь уярна) Хадтай газар халгаатай Мэдэсхийж яваарай Харийн хүмүүн хартай Сэрэмжилсхийж яваарай Хол газрын аяндаа Хонгор зээрдээ унаарай Холын бяцхан чамтайгаа Холдолгүй суун жаргаяа	Хөхий уулын шилд Хүйтний будан татна Хөөрхий мэлмэгэр чамайгаа Мартахын сэтгэл үгүй Хадтай өндрийн оройд Харанхуй будан татна Хайртай дунгар чамаасаа Хагацахын сэтгэл үгүй Хатуу газар халгаатай Мэдэсхийж яваарай, амраг мину Харийн хүмүүн хартай Сэрэмжилсхийж яваарай, алдрай мину Алс холын аяндаа Аранзал зээрдээ уная даа Амраг бяцхан чамтайгаа Амдаж очоод уулзъя даа

Энэ мэт түүний бичсэн дуу, шүлгийг хэвлэн нийтлэхдээ ардын дууны эсвэл Лу жанжин гүний бүтээлийн эмхэтгэлд оруулан хэвлэснээс гадна, үг үсгийн зөрөөтэй, хэмжээний хувьд ялгаатай хэвлэсэн байна. Мөн “Хөхий уулын шил” дуу олны дунд дэлгэрэхдээ мөр бадаг нэмэгдэж, хасагдан ардын дууны шинжтэй болсон бололтой. Цаашид эдгээр дуу, шүлгийг нарийвчлан судлахаас гадна Номч мэргэн гэгээний туурвисан өөр бүтээл бий эсэхийг нягтлах нь зүйтэй байна.

4.1. Номч мэргэн гэгээний аман домгийн шинжлэл

Бид 2020 оны 10 дугаар сарын 5-нд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт оршин суух өндөр настан Дагвын Нямаас “Өндөр гэгээн” хэмээх ламын тухай аман домгийг тэмдэглэж авсан билээ. Тус домогт өгүүлж буй “Өндөр гэгээн” гэдэг нь Өндөр гэгээн Занабазар биш байсан тул цаашид сурвалжлан тодруулсан юм. Ингэж үзэхэд энэхүү домог нь Номч мэргэн гэгээн Л.Лувсандомийдомэйн өмнөх дүрийн үйл хэрэг болоод хойд дүр нь хэрхэн мэндэлсэн

хийгээд хувилгааны хойд дүрээр хэрхэн тодорч Тэгшийн хүрээнд залагдсан тухай байсан юм. Тус домогт:

“Өндөр Гэгээн³ гэж лам Урианхайн бөө нарыг дарах гээд хөсөг хөтөлсөн явсан юм гэнэ лээ. Урианхайн наахна очоод шавь нараа хөсөг хөтлөө тун сайн бөхлөөрэй, өнөө шөнө аюул тавьж хононо. Мал хараа аргамжиж бөхлөөрэй гээд өөрөө жодгорт жаахан зайтай байгаад, намайг чимээ өгөхөөс нааш битгий та минь орж ирээрэй гэсэн гэнэ. Тэгээд шөнийн турш тэнгэр дуугараад, аянга буугаад хоносон гэнэ. Жодгор дээр нь гал унаад л шөнийн турш ниргэж хоносон гэнэ. Багш чимээ өгөхөөс нааш битгий орж ирээрэй гэсэн гээд чимээ чагнаад байж. Тэгсэн нэг чимээ өгсөн тэгээд ороод ирсэн чинь царай нь сүүмийчихсэн, шаргалтчихсан. Та минь тэгээд сайн хонов уу, миний энэ дор олбогийг хар гэсэн чинь сууж байсан олбогт нь Урианхайн холбого⁴ гэдэг юм шигчихсэн байсан. Ниргээд л байдаг ниргүүлэхгүй гээд дэвсгэрт нь ороод байсан нь тэр гэнэ. Тэгээд байж байсан чинь Урианхайгаас морь хөтөлсөн улсууд ирээд манай Даян дээрх уначихсан арга засал байна уу, бөө нэр унаад ухаангүй ойччихсон сэргэдэггүй гээд ирсэн гэнэ. Ирэхээр нь залагдаад явсан. Тэгээд Урианхайнуудын номгүй хар бөө нэрийг номтой хар бөө болгоод мянган харлаг адуу туугаад ирсэн юм гэнэ лээ. Мянган хар адуугаараа Тэгшийн хүрээг байгуулах гээд хүрээд ирсэн чинь хоёр хүүхэд хонинд явсан юм уу, аргалд явсан юм уу таарч гэнэ. Чиний нэрийг хэн гэдэг вэ гэсэн чинь Тэгшээ, нөгөөх нь Батсуурь гэдэг гэжээ. Тэгээд Тэгшийн хүрээ гэж нэрлээд хойд хүрээг байгуулсан юм гэнэ лээ гэж ярьдаг юм. Тэгээд тэр Өндөр Гэгээн бөө нэрийг дарчхаад буцаж явахдаа Жанжин гүн ноёныд очоод, буусан чинь авгай нь их тоомсоргүй хүн байж гэнэ. Чи яасан их хэмжээтэй хүүхэд вэ чамаар би шээсээ шавхруулаад, баасаа базуулчихъя гэж айлгаж байсан юм гэнэ лээ. Тэгээд Тэгшийн хүрээндээ хэзээ ч юм бүү мэд бурхан болсон. Тэгээд Жанжин гүн ноёны авгай Сартуулын Хамба Цорж лам тэрэгтэй, жуузтайгаа хүрээд ирлээ шүү гээд ухаангүй унасан юм гэсэн. Төрөөд 3 настай байхдаа Өндөр Гэгээний хэрэглэж байсан өврийн ном, хундага мундага ч юм уу, энэ тэрийг миний юм гээд аваад явсан, 3 настай хүүхэд. Тэгээд 5 настай залаад Жанжин гүн ноён хүүгээ өгөхгүй болохоор Гэгээн сахиус гэдэг юм аа тахичихсан юм гэсэн. Тэгээд сахиус тахичихаар гэр дээр нь улаан ямаа тоглоод унтуулахаа байсан. Ноён улаан ямаа тоглоод болохгүй болохоор ганц шөнө нойртой хоноё гээд 5 настай хүүгээ өгсөн юм гэсэн. Тэгээд тэр лам чинь Тэгшийн хүрээнд ирээд Тэгшийн хүрээ чинь дээд талд ганцхан бага шиг дуган харж байж байсан тэр нь Өндөр Гэгээний дуган байсан бэлгэцээлтэй цагаан соёмбот тэмдэг хэтээсээ л байж болохоо байх нь юу гэхэв дээ хэтээсээ явъя гээд тэмээн дээрээ суугаад Энэтхэг рүү явсан юм гэнэ лээ”⁵ хэмээж байна.

Ийнхүү Өндөр дүр буюу Хорло цорж ламын V дүр Дандарванчигийн номын хүч чадлыг өгүүлэхийн дээр дараагийн төрлийг олох газраа сонгон хэлж, Номч мэргэн гэгээн Лувсандамбийдомэй Лу жанжин гүний хүү болж мэндэлсэн тухай, түүнийг хийдэд хэрхэн залсан тухай, нутгаасаа харьд явсан тухай домоглон өгүүлжээ. Номч мэргэн гэгээний тухай урьд өмнө хэвлэсэн домгийн хувилбаруудыг үзвэл,

“Сартуулын Хорол цорж ламтан Тагна Урианхай яваад буцах замдаа Лу гүнийд морилжээ. Лу гүнээс хүрээнийхээ дуганы буцах будагмаажин будаг гүйсан гэнэ. Лу гүн будаг өгөхөөс татгалзсан байна. Тэгээд Хорол цорж ламтан Лу гүнд, хатны тань хормойг норгож байгаа авна даа гээд явжээ. Удалгүй Хорол цоржтон таалал төгсөж, Лу гүний хатан “Хорол цоржтон ирж явна” гээд ухаан алдан унаж, бие давхар болжээ. Лу гүний тэр хүү Цэдэнбал нь Хорол цоржийн хойд дүрээр тодорч, Тэгшийн хүрээнд Номч хутагтын сэнтийд заларчээ” [Пүрэвдорж, 2017: 239] гэдэг.

Харин судлаач Д.Түмэнжаргалын нийтэлсэн домгийн хувилбарт:

³ “Өндөр дүр” буюу Хорло цорж ламын V дүрийг хэлж байна.

⁴ Бөө, удганы хэц хэнгэргийн дотор талд хэлхэж дүүжилсэн ховхитой гонзгой төмрүүд: холбого гүйлгэх (холбогыг хүний биед оруулж хорлох). <https://mongoltoli.mn/dictionary/detail/109538>

⁵ Дагвын Ням. 1919-онд Завхан аймгийн Сонгино сумын Их ус гэдэг газар төрсөн. Эмэгтэй. 2020-оны 10-р сарын 5-нд Улаанбаатар хотод тэмдэглэн авав.

“Сартуул гүний хошууны хүрээ хийдийн хамба лам жил бүр дуганы мод гуйсаар 9 дуган босгожээ. Дахиад 10 дахь дуганаа барина мод өг, бас маажин тос өг гэж гуйжээ. Тэгэхээр нь: Хошууны ой мод сүйдлээ, өгөхгүй гэжээ. Гэтэл тэр лам Лу гүнд хэгжүүрхэж, - Тэгвэл чамайг шар чацгаар будаж байгаад авна гээд явжээ. Гэтэл мөдхөн нэг нүд жартгай дүртэй хүүг Лу гүнийд Сартуулын лам ид шидээр төрүүлээд, 5 настай байхад нь манай хувилгааны хойд дүр гээд Богдын лүгдэн гаргуулж, залж аваачжээ. Тэгээд Чадраабалыг Баруунзууд явуулж суулгажээ” [Түмэнжаргал, 2017: 129] хэмээжээ.

Эдгээр домогт Хорло цорж ламын V дүр Дандарванчигийн үйл хэрэг, номын ид чадлыг өгүүлж, Урианхай яваад буцах замдаа С.Лувсандондов гүнийд зочилсон эс бөгөөс Лу гүнээс дуган барих мод гуйсан болж гарч байна. Аль ч тохиолдолд дараа төрөлдөө Лу гүнийд төрж, хүссэн санаснаа гүйцээхээ “чамаар би шээсээ шавхруулаад, баасаа базуулчихъя”, “хатны тань хормойг норгож байгаа авна”, “чамайг шар чацгаар будаж байгаад авна” гэх мэтээр өгүүлж буй нь монгол хутагт хувилгаадын домгийн дараа төрлийнхөө мэндлэх газрыг сонгож хэлдэг өгүүлэмжийн жишээ юм. Угаас монгол хутагт хувилгаадын домогт урьд төрлийнхөө эрдмийг өвлөж төрөх, хэрэглэж байсан эд зүйлээ таних зэрэг эрдэм чадалтайн дээр дараа төрлийнхөө мэндлэх газрыг сонгож хэлсэн домгууд бий. Тухайлбал, Чин сүжигт номын хан Лувсанноровшаравын домогт:

“Лувсанноровшарав гэгээнтэн дайчин чин ван Цэдэнжав ноёныд очиж, хурал номд нь суралцаж байгаад: “Би Халхын төв нутагт нэг хурал номын газар байгуулах санаатай. Та Данжуур судрынхаа нэгийг, мянган чимгийнхээ⁶ хагасыг өгнө үү?” гэж гуйжээ. Тэгтэл: “Бид бадарчинд бурхан номоо худалдах болоогүй” гэжээ. Лувсанноровшарав буцах замдаа:

- Ван ноён манайд ном, чимгээ өгсөнгүй.

Хүү нь болж төрөөд

Хүзүүн дээр нь мордож

Ас Гомбын даваагаар

Асгаруулж байгаад авна даа” гэж хэлж байсан түүхтэй юм гэнэ. Үнэхээр Чин сүжигт номын ханы хоёрдугаар дүр Лувсандарванчиг Дайчин ван ноёныд хүү нь болон хувилж төрөөд, Номын хан гэгээнтнээр залагдан суухдаа урьд гэгээний “Мөнгөн амт” гэх монгол буу, хэлсэн ёсоороо “Шунхан Ганжуур”, “Мянган чимэг”-ийг авсан гэдэг” [Хутагт хувилгаадын домог, 2022: 82] хэмээх бол Зая гэгээний хоёрдугаар дүр “Лувсаннандаг гэгээнтэн мэндэлсэн домог”-т Зая гэгээний нэгдүгээр дүр Ганжуурын судрыг бүх сүмбүмээр нь залахаар Түшээт ханы Ханд чин вангийн хүрээнд очтол Вангийн хүрээнд биш Ванжуур гэдэг тайжийнд байгаа сураг гарчээ. “Гэгээнтэн уг тайжийнд морион, бэлэг сэлт барьж, их хөлгөн судрыг түр хугацаагаар залах учрыг айлтгахад, Ванжуур тайж элдэв арга саам хийгээд судруудаа өгсөнгүй. Хэргээ бүтээж чадаагүй Зая гэгээн тайжид хандан: “За, судраа өгсөнгүй гээд танд гомдох зүйл надад үгүй ээ. Гэхдээ манай хүрээ ганжуурыг чинь Ванжууртай нь залах цаг ирж мэдэх юм шүү!” гэжээ. Түүнээс хойш Зая гэгээний хоёрдугаар (нэгдүгээр) дүр номын агаарт дүрээ уусгаж жанч халжээ.

Дараагийн дүр хаана мэндэлснийг Далай лам, Банчин богд нараар сунтаг шүүлгэхэд, нөгөө Вангийн хошууны Ванжуур⁷ тайжийнд хувиран төрсөн байна гэжээ... Тэгээд нэгэнт Заяын хүрээнд Ванжуур тайж өөрөө ч залагдаж ирэхдээ нөгөө Ганжуурын судруудаа ачаад иржээ” [Хутагт хувилгаадын домог, 2022: 58] гэдэг. Зая гэгээний хоёрдугаар дүрийн мэндэлсэн домог ийм бол гуравдугаар дүрийн домог нь энэхүү домгоос улбаалж, “Хоёрдугаар гэгээнтэн шашнаа дэлгэрүүлээд, таалал болохоосоо өмнөхөн “За би энэ төрөлдөө хүрээнээсээ хол газар төрж, шавь нартаа их төвөг чирэгдэл учруулсан. Аав маань ч намайг ширээнд суулгахгүй гэж та нарыг сандаргаж байсан. Харин удаах төрөлдөө даага эцээхгүй газарт төрнө” гэжээ. Түүний энэхүү гэрээслэл мэт үг ёсоор болж, Заяын хүрээнээс хол биш, хойд Тамирын голын хөвөөнд Сайн ноён хан аймгийн Цэцэн засгийн хошуу ноён, чин ван Цэнгүнжавын гэрт хувиран мэндэлжээ” [Хутагт хувилгаадын домог, 2022: 61] гэдэг. Түүнчлэн Өндөр гэгээн Занабазарын домогт бол: “Халхын очирбат Түшээт хан Гомбодорж хээр талд гөрөөлж явсаар Усанзүйл

⁶ Цэдэнжав ноёны Төрөөс хүртсэн цол чимэг, гуншинг хэлсэн бололтой.

⁷ Зая гэгээний хоёрдугаар дүр Лувсаннандагдэлэгнамжил (1716-1765) нь Түшээт хан аймгийн Халхын умар замын баруун гарын зүүн этгээдийн ван Цэрэнпилийн хошууны мэйрэн Ванжуурын гэрт мэндэлжээ.

хэмээх нуурын захад хүрсэнд, нэгэн танихгүй лам хүн ганцаар ном уншин сууж байхыг үзээд, тэсэлгүй баярлаж сүсэглэсээр:

- Та аль газрын ямар нэртэй хүн бэ? хэмээн асуусанд,

- Би Төвөдийн хойд Цан нутгийн Жавзандарнад⁸ хэмээгч лам билээ. Эдүгээ танай Халхын газар усыг тахиж сууна. Дараагаар Халхын газарт очирбат Түшээт хан Гомбодорж таны хөвгүүн болон мэндэлж, шашиныг мандуулан, амьтныг жаргуулна гэж хэлээд, удалгүй үзэгдэхгүй болжээ” [Хутагт хувилгаадын домог, 2022: 20-21] гэсэн нь дээр өгүүлсэнчлэн монгол хутагт хувилгаадын домгийн тогтсон өгүүлэмжийн нэг бөгөөд Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн домгийн хувилбарууд энэхүү уламжлалыг хадгалсан нь харагдаж байна. Одоогоор бидэнд мэдэгдээд буй домгийн гурван хувилбарт энэхүү ижил төстэй өгүүлэмж давтагдаж байна.

4.2. Номч мэргэн гэгээний өв

Судлаач Ц.Сайннямбуу, Д.Бат нарын “Ханхөхийн хошууны ноён Лу жанжин гүний хөвүүн Номч мэргэн гэгээнтэн” номд Өвөрмонгол дахь Алтан тэвшийн хийдэд буй Номч гэгээний эдэлж хэрэглэж байсан зүйлс, ном бүтээлийн тухай нэлээд дэлгэрэнгүй мэдээлжээ. Гэвч Монгол Улсад гэгээнтний эдэлж хэрэглэж байсан зүйлс буй эсэхэд өнөө хэр тодорхой судалгаа, мэдээлэл үгүй байна. Тиймээс бид нутаг усныхан болоод ойр төрөл хүмүүсээс нь тодруулсны эцэст гэгээнтний хэрэглэж байсан эрх, аяга, шоо Номч мэргэн гэгээний шавь, бичээч асан А.Натсүрэнгийн удмынханд хадгалагдаж буйг мэдсэн юм.

Дээр дурдсан номд хэвлэгдсэн Гүн овогтой Пүрэвийн ярианд “Гэгээнтнийг Түвдэд морилж байхад манай сумын “Баян-Айраг”-аар нутагладаг Натсүрэн бандиахай очиж уулзсан юм гэнэ лээ. Тэр чинь гэгээнтний бичээч хийж явсан хүн. Гэгээнтэн нутгаас хүн ирлээ хэмээн баярлаж, “Сонгино хайрхан сайн байна уу?”, “Цэцэн хайрхан сайн байна уу?” гэж асуугаад дараа нь “Та нар минь сайн байцгаана уу?” гэж лам нартайгаа мэндэлсэн гэнэ лээ” [Сайннямбуу, Бат, 2005: 62] гэх буюу Дагва овогтой Нямын ярианд “Манай нутгийн Аюурзана овогтой Натсүрэн бандиахай Гэгээнтний бичээч явсан юм гэнэ лээ. ...Гэгээний тухай ярихыг сонссон” [Сайннямбуу, Бат, 2005: 62] гэж өгүүлсэн байдаг. Тэгвэл энд өгүүлж буй А.Натсүрэнгийн удам болох Д.Гармаад Мэргэн гэгээний хэрэглэж байсан эрх, аяга, шоо одоо хадгалагдаж байна.




Аюудай овогтой Натсүрэн (1891-1977) нь Завхан аймгийн Сонгино сумын Баян-Айраг багт мэндэлсэн бөгөөд 10 настайгаас Тэгшийн хүрээ, Галуутайн хүрээнд шавилан сууж, Маарамбын дамжаа барьжээ. Гэгээнтний өвүүдийг хадгалж буй Д.Гармаа өвөө А.Натсүрэнгийн тухай дурсахдаа “Өвөө маань монгол, төвөд, кирилл шинэ үсэг мэддэг, эрдэмтэй лам байсан. Манай өвөө багшийнхаа тухай ярихдаа их эрдэм номтой хүн байсан гэж ярьдаг байж билээ. Багш нь цөвүүн цаг болсон, ингэж байж болохгүй. Хүрээ хийд тараад хүний ёсноос гажууд зүйл болох нь ээ, бурхан номоо хүн хүрэхгүй газар нуугаарай хэмээн хэлж байсан гэнэ лээ. Мөн багш нь хэлэхдээ чи хар болж амьдрахгүй бол аминд чинь аюултай гээд эрх, аяга, зандан шоо өгөөд, чи 86 хүртэл насална аа хүнд их тус хүргэж яваарай гэж захисан гэдэг юм. Гэгээнтэн явахдаа ганц тэмээн дээр жодгор тавиад түүн дээрээ суугаад ганц шавиараа хөтлүүлээд Төвөд рүү явсан. Хүргэж өгсөн шавийгаа чи битгий яваа гэж хэлсэн боловч ирээд гэрлээд олон хүүхэдтэй болоод бурхан болсон гэнэ лээ” хэмээн ярьсан юм. Мөн түүний ярьснаар багш нь чи баригдана, чи хар болж амьдар гэснээс хойш А.Натсүрэн Шомбон гэдэг хүнтэй ханилж 2 хүүтэй болсон бөгөөд судас барьж, оточ хийж олон хүнд тус хүргэж амьдарсан ажээ. Номч мэргэн гэгээний үлдээсэн эдгээр зүйлс А.Натсүрэнгийн хүү Н.Дамдинсүрэнд өвлөгдөж, өдгөө Н.Дамдинсүрэнгийн охин Д.Гармаад хадгалагдаж байна. Д.Гармаагийн аав Н.Дамдинсүрэн


⁸ Өндөр гэгээний анхны дүр нь Энэтхэгт Жад Довчин нэртэй байгаад энэ цагаас хойш түүний дүрүүд тодорсоор арван зургаадугаар дүр нь Жавзандарнад Гунгаанямбуу (1574-1634) юм.

мөн зоос татаж, ном дарж, эрх, шоогоор мэргэлдэг байсан бөгөөд “сайд нар хар машинтай ирж шөнө аваад явдаг сайн оточ байсан” хэмээн дурсан ярьсан юм.


Д.Гармаад хадгалагдаж буй өв гэвэл амсар, ёроолыг мөнгөлсөн тагш нэг ширхэг. Үүний амсрын диаметр 12 см, ёроолын диаметр 7 см, өндөр нь 8 см байна. Модон шоо гурван ширхэг байна. Үүний хэмжээ 1х1 см. Эрхний нийт урт 88 см, бөөрний голч 1 см байна. Эдгээрийг зургаар хавсаргав.



Зураг 1. Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн хэрэглэж байсан аяга



Зураг 2. Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн хэрэглэж байсан шоо



Зураг 3. Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэйн хэрэглэж байсан эрх

5. Дүгнэлт

- Номч мэргэн гэгээн Л.Лувсандамбийдомэй бол С.Лувсандондовын гуравдугаар хүү бөгөөд нэр нь Л.Чадраабал, 1883 оны хонь жил төрж, 1886 (1887) онд Тэгшийн хүрээнд залагдсан байна. Түүнчлэн Лувсанравдандорж, Равдандорж гэдэг бол түүний нэрийн хувилбар бөгөөд сахирын нэр нь юм.
- Л.Лувсандамбийдомэйн бичсэн дуу, шүлгийг хэвлэн нийтлэхдээ ардын дууны эсвэл Лу жанжин гүний бүтээлийн эмхэтгэлд оруулан хэвлэснээс гадна, үг үсгийн зөрөөтэй, хэмжээний хувьд ялгаатай хэвлэсэн байдал ажиглагдаж байна. Цаашид эдгээр дуу, шүлгийг нарийвчлан судлахаас гадна Номч мэргэн гэгээний туурвисан өөр бүтээл бий эсэхийг нягтлах нь зүйтэй.
- Амаар уламжилсан домгийн хувилбаруудыг ажиглахад монгол хутагт хувилгаадын домог дахь урьд төрлийнхөө эрдмийг өвлөж төрөх, хэрэглэж байсан эд зүйлээ таних, дараа төрөлдөө мэндлэх газрыг сонгож төрөх зэрэг өгүүлэмжийг хадгалсан нийтлэг шинж ажиглагдаж байна.
- Номч мэргэн гэгээний хэрэглэж байсан эд зүйлс Өвөрмонголын Алтан тэвшийн хийдэд байдгийг өмнөх судлаачид мэдээлсэн байна. Харин Монгол Улсад оточ, бичээч А.Натсүрэнгийн удмынханд хувилгааны аяга, эрих, шоо зэрэг хадгалагдаж байна.
- Номч мэргэн гэгээн Лувсандамбийдомэйн намтар, уран бүтээл, шашин номын үйл ажиллагаа, өв зэргийг цаашид нарийвчлан судалж, зөрөөтэй мэдээллүүдийг цэгцлэх шаардлагатай байна.

Ном зүй

- Амаржаргал, Б., Палам, Б.** (2004). *Монгол төрийн түшээд: Лу жанжин гүн, То ван*. То ван судлалын эрдэм шинжилгээний цуврал бичиг №25. Хянан тохиолдуулсан О.Цэвэгдорж, Д.Дуламсүрэн. Улаанбаатар: 68 х. [Amarjargal, B., Palam, B. *Mongol töriin tüsheed: Lu janjin gün, To van*. [Mongolian Statesmen: Lu janjin gün, To van] To van sudlaliin erdem shinjilgeenii bichig №25. Ulaanbaatar: 2004]
- Гомбожав, Л.** (2017). *Бурхан Лу жанжин гүн*. Хянан тохиолдуулсан Б.Амаржаргал. Улаанбаатар: 258 х. [Gombojav, L. *Burkhan Lu janjin gün*. Ulaanbaatar: 2004]
- Гүрсэд, М.** (2001). *Цэцэг эзэлсэн дууч Сэdbазарын Лувсандондов гүн*. Улаанбаатар: 85 х. [Gürsed, M. *Tsagiig ezelsen ikh duuch Sedbazariin Luvsandondov gün*. Ulaanbaatar: 2001]
- Монгол ардын уртын дуу.** (1984). Монгол аман зохиолын чуулган V. Эмхэтгэн боловсруулж, удиртгал тайлбар бичсэн Х.Сампилдэндэв, К.Н.Яцковская. Редактор Д.Цэрэнсодном. Улаанбаатар: УХГ. 271 х. [Mongol ardiin urtiin duu. [Mongolian Long Song]. Ulaanbaatar: 1984]
- Нарангэрэл, О.** (2014). *Очирваань бурханы орон Отгонтэнгэр хайрхны цадиг оршвой*. Улаанбаатар: 310 х. [Narangerel, O. *Ochirvaani burkhnii oron Otgontenger khairkhny tsadig orshvoi*. Ulaanbaatar: 2014]
- Өрнөхдэлгэр, Д.** (2020). *Гүн найрагч Сэdbазарын Лувсандондов: Намтар, уран бүтээл*. Редактор А.Батсуурь, Д.Ганболд. Улаанбаатар: 204 х. [Urnukhdelger, D. *Gün nairagch Sedbazaryn Luvsandondov: Namtar, uran büteel*. [Sedbazaryn Luvsandondov, the Master Poet: Biography and Works] Ulaanbaatar: 2020]
- Пүрэвдорж, Г.** (2017). *Сарт гол цэцэн вангийн хошууны шастир оршвой*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК. 296 х. [Purevdorj, G. *Sart gol tsetsen vangiin khoshuuny shastir orshvoi* [The Chronicle of Sart Gol Tsetsen Van's Banner exists] Ulaanbaatar: 2017]
- Сайннямбуу, Ц., Бат, Д.** 2005. *Ханхөхийн хошууны ноён Лу жанжин гүний хөвүүн Номч мэргэн гэгээнтэн*. Редактор Ч.Авдай. Тайвань: 180 х. [Sainnyambuu, Ts., Bat, D. *Khankhökhiiin khoshuunii noyon Lu janjin güinii khövüün Nomch Mergen Gegeenten*. [Nomch Mergen Gegeenten, son of Noyon Lu Jangjin Gün of Khankhökhii Banner] Taiwan: 2005]
- Түмэнжаргал, Д.** (2010a). *Засагт хан аймгийн туслах жанжин, Их Элжигэн хошууны засаг ноён С.Лувсандондовын харилцсан бичиг захидлууд*. Монголын лам ноёдын мянган бичиг захидал II. Редактор Т.Хүрэлбаатар, Т.Мэндсайхан. Улаанбаатар: 468 х. [Tümenjargal, D. *Zsagt khan aimgiin tuslakh janjin, Ikh Eljigen khoshuunii zasag noyon S.Luvsandondoviin khariltssan bichig zakhidluud*. [Correspondence of S. Luvsandondov, Deputy General of Zasagt Khan Aimag and Zasag Noyon of Ikh Eljigen Banner]. Ulaanbaatar: 2010a]
- Түмэнжаргал, Д.** (2010б). *Чин ачит бэйл Л.Гончигдамбын харилцсан захидлууд*. Монголын лам ноёдын мянган захидал. Цуврал III дэвтэр. Редактор Ц.Ишдорж. Улаанбаатар: 277 х. [Tümenjargal, D. *Chin*

achit beil L.Gonchigdambiin khariltssan zakhidluud. [The Correspondence of Chin Achit Beil L. Gonchigdamda]. Ulaanbaatar: 2010b]

Түмэнжаргал, Д., Мэндсайхан, Т. (2017). *Элжигэн халхын түүх*. Хоёрдугаар дэвтэр. Хянан тохиолдуулсан Ц.Ишдорж, Л.Гомбожав. Улаанбаатар: 334 х. [Tümenjargal, D., Mendsaikhan, T. *Eljigen khalkhyn tiiikh*. [The History of Eljigen Khalkh]. Ulaanbaatar: 2017]

Хутагт хувилгаадын домог. (2022). Эмхэтгэн боловсруулж, удиртгал, тайлбар бичсэн Т.Баясгалан. Улаанбаатар: 296 х. [*Khutagt khuvilgaadyn domog*. [Legends of the Khutagtu Reincarnations]. Ulaanbaatar: 2022]

Шүлэгч Лувсандондовын бүтээл. (1989). Дурсгалт бичгийн чуулган, Tom. XXIV, fasc. 1. Эмхэтгэсэн М.Гүрсэд, Б.Амаржаргал, Ц.Баярсүрэн. Редактор Ж.Цолоо. Улаанбаатар: 121 х. Shülegch Luvsandondovyn büteel. Dursgalt bichgiin chuulgan. Tom. XXIV, fasc. 1. [The works of poet Luvsandondov. Corpus scriptorum Mongolorum. Tom. XXIV, fasc. 1] Ulaanbaatar: 1989]